



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2022 оны ээлжит 11 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 11 дүгээр хуралдаан 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр холимог оролцоотой (биеэр болон цахим) хэлбэрээр зохион байгуулагдсан болно.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 11 дүгээр хуралдаанаар Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд ХХЗХ-ноос батлах багц журам, аргачлалын баримт бичгүүд болох “Бүртгэлийн үйл ажиллагаа явуулах журам”; “Тоон гарын үсгийн гэрчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хадгалах журам”; “Гэрчилгээ олгох үйлчилгээний тариф тогтоох аргачлал”-ын төслүүдийн тухай; “Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийсэн шалгалт”-ын тайлангийн танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай); Бусад асуудал (“Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт”-ын баримт бичгийн талаар ОНДО ХХК-иас ХХЗХ, Хорооны гишүүдэд ирүүлсэн албан тоотын талаар танилцуулга зэрэг асуудлыг хэлэлцэн нийт 6 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр хугацаатай үүрэг, чиглэлийн холбогдох бүтцийн нэгжид үүрэг болгохоор шийдвэрлэв.

УИХ-аар Цахим гарын үсгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр соёрхон баталж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн болно. Энэхүү хуулийн 32 дугаар зүйлд Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн талаар хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх¹ чиг үүргийг Харилцаа холбооны зохицуулах хороонд даалган хуульчилсан бөгөөд тус хорооны холбогдох нэгжээс тогтоолын төсөл, 3 хавсралт журам, аргачлалын төслийг Захиргааны ерөнхий хуулийн дагуу боловсруулсан. Үүнд: Цахим гарын үсгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5 дах заалтад “гэрчилгээний мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хадгалах журмыг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих,” гэж заасны дагуу “Тоон гарын үсгийн гэрчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хадгалах журам”; хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.6 дах заалтад “энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу бүртгэлийн үйл ажиллагаа явуулахтай холбогдсон журам батлах,” гэж заасны дагуу “Бүртгэлийн үйл ажиллагаа явуулах журам”; “Гэрчилгээ олгох үйлчилгээний тариф тогтоох аргачлал” зэрэг болно. Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 11 дүгээр хуралдаанаар ЗБХГ, ЗЗҮТЗГ, ЗУХАГ-аас хамтран боловсруулсан Цахим гарын үсгийн хуульд заасан ХХЗХ-ны чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “Журам, аргачлал батлах тухай” танилцуулга, тогтоолын төсөл, тогтоолын хавсралт 3 журам, аргачлал баримт бичгийн төсөл, саналын товчоо, нөлөөллийн шинжилгээ, холбогдох материалыг авч хэлэлцэв. Тус хуралдаанаас Харилцаа холбооны тухай хуулийн 9

¹ Цахим гарын үсгийн тухай хуулийн 32.1

дүгээр зүйлийн 9.1.2, 9.1.15 дах заалт, Цахим гарын үсгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.5, 32.1.6 дах заалтыг тус тус үндэслэн 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн “Журам, аргачлал батлах тухай” тогтоолыг батлахаар шийдвэрлэж, уг тогтоолын Нэгдүгээр хавсралтаар “Тоон гарын үсгийн гэрчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хадгалах журам”-ыг, Хоёрдугаар хавсралтаар, “Бүртгэлийн үйл ажиллагаа явуулах журам”-ыг Гуравдугаар хавсралтаар “Гэрчилгээ олгох үйлчилгээний тариф тогтоох аргачлал”-ыг батлав. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 45 тоот тогтоол, 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 36 тоот тогтоолыг тус тус хүчингүй болгов. Энэхүү тогтоолыг хавсралтын хамт ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан бүртгүүлэхээр хүргүүлж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн 6061 тоот улсын бүртгэлд 2022 оны 12 дугаар сарын 17-ны өдөр бүртгүүлэн баталгаажуулав.

ХХЗХ-ны Даргын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/254 тоот тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд Улаанбаатар хотын телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг газар дээр нь шалгаж холбогдох хууль тогтоомж, нөхцөл шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилтийн байдалд хийсэн хэмжилт, шалгалтыг 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн хийж гүйцэтгэн газар дээр нь мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Тус хорооны хуралдаанд ажлын хэсгээс “Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийсэн шалгалт”-ын тайлангийн танилцуулгыг хэлэлцүүлж, энэ хүрээнд телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хэрэгжилт, гэрээний эрх зүй, бичиг баримтын бүрдэлт, тусгай зөвшөөрлийн хамрах хүрээ, тусгай зөвшөөрлийн төлбөр төлөлтийн байдал, техник, стандартын хэрэгжилт, мөрдөлт, аюулгүй ажиллагаа, телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага, зар сурталчилгааны зохицуулалтын журмын хэрэгжилтийн байдалд хийсэн хяналт шалгалтын ажлын тайлан, санал дүгнэлтийг танилцуулав. Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевизийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын дүнг үзүүлэлт тус бүрээр харгалзах оноог өгч, авсан оноогоор нь нэгтгэн гаргасан үнэлгээ болон шаардлага хангахгүй үзүүлэлтүүдийг хүснэгтэд нэгтгэн шалгалтын дэлгэрэнгүй тайланд хавсаргасан болно. Шалгалтын үр дүнг үндэслэн нэр бүхий 11 телевизийн үйлчилгээ эрхлэгч нарт албан хугацаатай үүрэг даалгавар, шаардлага хүргүүлэх арга хэмжээ авахаар тогтов.

Бусад асуудлын хүрээнд, Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 11 дүгээр хуралдаанд РДХЗГ-аас "Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт"-ын баримт бичгийн талаар ОНДО ХХК-иас ирүүлсэн албан тоотын талаар тайлбар, танилцуулгыг хийлээ. Хэлэлцсэн асуудлаар "Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт"-ын баримт бичгийн төслийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлээр хугацаатай удирдамж, чиглэлийг холбогдох бүтцийн нэгжийн удирдлагад үүрэг болгов.

ХХЗХ-ны 2022 оны ээлжит 11 дүгээр хуралдаанд тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай) холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 5 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 5 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн 54 тоот тогтоолын хавсралтаар 10 хуулийн этгээдийн 10 тусгай зөвшөөрлийг 45 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн 55 тоот тогтоолын хавсралтаар 62 хуулийн этгээдийн 74 тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн;
- Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15 дах заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.1.1 дэх заалт болон 5.3 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн 56 тоот тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөлд нэмэлт оруулсан;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 57 тоот 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 57 тоот тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдэд 5 тусгай зөвшөөрлийг шинээр олгон тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2022-12-03